



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Гадаадын сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” 2010 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 391 дүгээр тушаалын Оросоогийн Чулуунбилэгтэй холбогдох хэсгийн “1 жилийн” гэснийг “2 жилийн”, Бат-Орхоны Мөнх-Учралтай холбогдох хэсгийн “La Treub их сургуулийн магистрантурт Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр 1,5 жилийн” гэснийг “АНУ-ын Норт Вестерн Политехникийн их сургуулийн магистрантурт мэдээлэлийн технологи, компьютерийн системийн инженерийн мэргэжлээр 2 жил”, Дашдондогийн Мөнгөнчимэгтэй холбогдох хэсгийн “АНУ-ын Ютагийн их сургуулийн магистрантурт хүнсний үйлдвэрийн технологийн чиглэлээр” гэснийг АНУ-ын Норт Вестерн Политехникийн их сургуулийн магистрантурт хүнсний үйлдвэрийн менежментийн мэргэжлээр” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД

Ё.ОТГОНБАЯР

